

**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД**

2024-11-06

Улаанбаатар хот

Хяналтын журмаар гомдол гаргах тухай

“Монголын Үндэсний Их Сургууль” НҮТББ-ын нэхэмжлэлтэй Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын улсын ахлах байцаагч Ш.Уртнасанд холбогдох захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 0564 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 0639 дугаар магадлалыг эс зөвшөөрч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.

1-д заасан “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах” гэсэн үндэслэлээр энэхүү гомдлыг гаргаж байна.

Нэг. Үүсч бий болсон нөхцөл байдалд хуулийг зөрүүтэй тайлбарлан хэрэглэсэн талаар:

“Монголын Үндэсний Их Сургууль” НҮТББ нь анх 1998 онд “Чандмань Эрдэнэ” коллеж нэртэй байгуулагдаж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 34 дүгээр тушаалаар “Чандмань Эрдэнэ” коллеж нэрээ өөрчилж “Монголын Үндэсний” коллеж болсон тус өөрчлөлттэй холбоотой улсын бүртгэлийг зохих журмын дагуу шинэчлэн бүртгүүлэхийг БСШУ-ны сайдаас даалгаж шийдвэрлэж байсан.

Монголын Үндэсний коллежийг БСШУ-ны сайдын 2004 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 238 дугаар тушаалаар “дээд сургууль”-ийн ангилалд хамааруулсан.

Ийнхүү 2004 оноос Монголын Үндэсний дээд сургууль нэрээр үйл ажиллагаа явуулж байгаад БСШУ-ны сайдын 2012 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/454 дүгээр тушаалаар “Монголын үндэсний дээд сургуулийг 2012 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн их сургуулийн ангилалд хамааруулсугай” гэж шийдвэрлэсэн. Ийнхүү сургуулийн ангилал өөрчлөгдсөнтэй холбогдуулан сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгүүлэхийг Монголын үндэсний дээд сургуулийн захиралд даалгасан байдаг. Тус тушаалын дагуу сургалтын ажил эрхлэх 980118 дугаартай тусгай зөвшөөрлийг олгосон.

БСШУ-ны сайдын дээрх тушаалаар Монголын Үндэсний дээд сургуулийг “их сургууль”-ийн ангилалд хамааруулсанаас бус оноосон нэрийг нь огт өөрчлөөгүй бөгөөд ийнхүү өөрчлөх хууль зүйн үндэслэл байгаагүй байна.

Монголын Үндэсний дээд сургуулийг их сургуулийн ангилалд хамааруулсанаас хойш жил гаруйн дараа буюу 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Монголын Үндэсний Их Сургууль нэртэй хязгаарлагдмал хариуцлагатай компанийг шинээр үүсгэн байгуулах

шийдвэрийг иргэн Л.Мөнхбат дангаараа гаргаж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байдаг.

Ийнхүү боловсролын үйл ажиллагаа явуулдаг “Монголын Үндэсний дээд сургууль” болон ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах “Монголын Үндэсний Их Сургууль” ХХК гэсэн бие даасан хоёр хуулийн этгээд тус улсад бий болсон.

“Монголын Үндэсний дээд сургууль” нь улсын бүртгэлийн бүртгэлд 980118 гэсэн регистрийн дугаартайгаар бүртгэгдсэн бол “Монголын Үндэсний Их Сургууль” ХХК нь 9133615 гэсэн дахин давтагдашгүй регистрийн дугаартайгаар бүртгэгдсэн байх бөгөөд хоёр өөр бие даасан зорилго, үйл ажиллагаа бүхий хуулийн этгээд юм. Үүнийг хүснэгтээр үзүүлвэл:

Шалгуур	“Монголын Үндэсний коллеж”-ийн тухайд	“Монголын Үндэсний их сургууль” ХХК-ийн тухайд
Үүсгэн байгуулагдсан огноо	Анх 1998 онд “Чандмань Эрдэнэ” коллежийг үүсгэн байгуулсан;	2013 онд “Монголын Үндэсний Их Сургууль” ХХК-ийг анх удаа үүсгэн байгуулсан;
Үүсгэн байгуулагч	Монгол Улсын иргэн болон хуулийн этгээд (компани) гэсэн хоёр үүсгэн байгуулагчтай;	Монгол Улсын нэг иргэн (Л.Мөнхбат);
Нэрээ өөрчилж байсан эсэх	2002 онд “Чандмань Эрдэнэ” коллежийн оноосон нэрийг “Монголын Үндэсний коллеж” болгон өөрчилсөн;	Монголын Үндэсний Их Сургууль ХХК-ийн нэрийг өөрчилж байгаагүй;
Регистрийн дугаар	“Монголын Үндэсний коллеж” нь Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн хувьд дахин давтагдашгүй 980118 тоот регистрийн дугаартай болно;	“Монголын Үндэсний Их Сургууль” ХХК нь Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн хувьд дахин давтагдашгүй 9133615 тоот регистрийн дугаартай болно;
Үйл ажиллагааны чиглэл	“Монголын Үндэсний коллеж” нь боловсрол сургалтын үйл ажиллагаа эрхлэх зорилготой;	“Монголын Үндэсний Их Сургууль” ХХК нь ашгийн төлөө зорилготой;
Боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсэх	“Монголын Үндэсний коллеж” нь боловсрол сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлийн дагуу үйл ажиллагаа явуулдаг;	“Монголын Үндэсний Их Сургууль” ХХК-д БСШУЯ-аас боловсрол сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож байгаагүй болно ¹

¹ Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 7/3699 дугаартай албан бичгээр “2013 онд иргэн Л.Мөнхбатын үүсгэн

Боловсролын байгууллагын ангилалын тухайд	“Монголын Үндэсний коллеж” нь 2004 онд “дээд сургууль”-ийн, 2012 онд “их сургууль”-ийн ангилалд орсон байдаг;	“Монголын Үндэсний Их Сургууль” ХХК нь “дээд сургууль”-ийн төдийгүй “их сургууль”-ийн ангилалд орж байгаагүй;
---	---	---

Нэхэмжлэгч нь анх “Монголын Үндэсний дээд сургууль” НҮТББ нэртэйгээр 980118 гэсэн дугаартай тамга дарж шүүхэд нэхэмжлэл гаргасан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дээр дурдсан хууль бус үйл ажиллагаа нь илчлэгдэж ил болоход² тамгаа өөрчилж 9133615 гэсэн дугаартай тамга болгон өөрчилсөн.

Эдгээрийг бүхэлд нь нэгтгэн дүгнэвэл нэхэмжлэгч нь угтаа сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч байгаагүй, харин бүртгэлийн байгууллагыг төөрөгдүүлж, алдаа гаргуулсны улмаас өөр хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг өөрийн нэр дээр бүртгүүлсэн хуулийн этгээд юм.

Хууль тогтоомжийг дагаж мөрдөх, хуульд заасан журмын дагуу үйл ажиллагаа явуулах нь зөвхөн төрийн байгууллагад бус иргэн, хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна. Хууль бус зүйлийг улсын бүртгэгч төөрөлдөж, мэхлэгдэж бүртгэсэн нь хууль ёсны болж зөвтгөгдөхгүй, хууль бус байсан болохыг нь тогтоосон тохиолдолд залруулж зөвтгөх нь төрийн байгууллага буюу улсын бүртгэлийн байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг юм.

Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүхээс дээрх байдлаар хууль тогтоомжийг зөрчиж хийлгэсэн хууль бус улсын бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас залруулахаар гарсан улсын байцаагчийн дүгнэлтийг холбогдох хуулийг буруу тайлбарлан хэрэглэх замаар жинхэнэ бодит үйл баримтыг гуйвуулж үнэний эсрэг дүгнэлт хийх замаар нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй юм.

Хоёр. Анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн тухайд:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /2003/-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Хуулийн этгээдийг дор дурдсан байгууллага /цаашид “бүртгэх байгууллага” гэх/ бүртгэнэ: 7.1.4-д “соёл, боловсрол, сургалтын байгууллагыг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь” гэж, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Бүртгэх байгууллага нь хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхээс дараах үндэслэлээр татгалзана”, 18.1.1-д “улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу”, 18.1.2-д “өөрчлөн

байгуулсан “Монголын Үндэсний их сургууль” ХХК-д боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал гараагүй байна” гэсэн нотлох баримт ирүүлсэн. Ийнхүү “Монголын Үндэсний их сургууль” ХХК нь тусгай зөвшөөрөл авч байгаагүй болох нь илэрхий нотлогдож байгаа болно.

² Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 04 сарын 05-ны өдрийн урьдчилсан хэлэлцүүлгээр энэ нь тодорхой болсоны дараа тамга тэмдэгээ сольсон. Хавтаст хэрэг 2, 10-23 дахь тал

байгуулагдаж байгаа хуулийн этгээдийн хувьд Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 15.3, 15.4-д заасан үндэслэл байгаа” гэж заасан.

Үүнээс үзэхэд сургуулийг боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаа тусгай зөвшөөрөл олгосон байгууллага буюу Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам бүртгэхтэй холбоотой зохицуулалт байхад улсын бүртгэлд хуулийн этгээд шинээр бүртгүүлэх харилцаанд тулган хамааруулж хэрэглэсэн нь алдаа болсон.

Анхан болон давж заалдах шатны шүүхээс дээрх байдлаар хуулийг буруу тайлбарлаж, “... хуульд заасан улсын бүртгэлд бүртгүүлэхэд шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлэн зохих журмын дагуу хандсан, өмнө нь эрх бүхий байгууллагаас нэгэнт олгогдсон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд бүртгэлийн байгууллага дээрх хуулийн 18.1-д зааснаас тохиолдолд мэдүүлгийг хүлээн авах үүрэгтэй буюу бүртгэхээс татгалзах үндэслэлд хамаарахгүй гэж үзнэ” гэж дүгнэсэн.

Гурав. Захиргааны ерөнхий хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн тухайд:

Анхан болон давж заалдах шатны шүүх Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т заасныг маргаан бүхий харилцаанд зөв тайлбарлан хэрэглэж чадаагүй.

Хариуцагчийн шийдвэр буюу захиргааны акт өмнөх бүртгэлийг “илт хууль бус” болохыг тогтоох гэсэн Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлд хамаарах үндэслэлээр гарсан. Гэтэл шүүх хууль бус буюу хүчингүй болгох захиргааны актад хамаарах Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т заасан хөөн хэлэлцэх хугацааг баримтлан дүгнэлт хийсэн.

Түүнчлэн хэрэгт авагдсан эргэлзээгүй нотлох баримтуудыг үндэслэл болгон авч үзвэл адил төсөөтэй нэртэй хоёр өөр хуулийн этгээдийн баримт бичгийг хольж хутган улсын бүртгэгчийг төөрөгдүүлж, хууран мэхэлсэн дүр зураг илт байдаг. Энэ тохиолдол нь Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.4-т заасанд хамаарах бөгөөд тус хуулийн 48.3-т заасан хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэгдэхгүй юм.

Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүх Захиргааны ерөнхий хуулийн ялгаатай зохицуулалтуудыг маргаан бүхий нөхцөл байдалд хольж солин хэрэглэж хууль хэрэглээний алдаа гаргасан байна.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалын дүгнэлтүүд үндсэндээ ижил бөгөөд утга агуулга дүгнэлтүүд ижил байгаа ба анхан шатны шүүхийн хууль хэрэглээний алдааг засахгүйгээр, үндэслэлтэй зөв дүгнэсэн гэж шийдвэрлэсэн магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадаагүй байна.

Дөрөв. Нэг асуудлаар эсрэг тэсрэг шийдэл бүхий шийдвэрийг давж заалдах шатны шүүх гаргасан тухайд:

Энэхүү маргаантай харилцаанд хамаарах Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 0213 дугаар магадлалыг Улсын дээд шүүхээс хяналтын журмаар хэлэлцэх үндэслэлгүй гэж үзснээр хүчин төгөлдөр болсон бөгөөд маргаанд холбогдох дараах чухал дүгнэлтүүдийг өгсөн.

Магадлалын хянавал хэсгийн 5.3-т "... "Чандмань-Эрдэнэ" коллежоос "Монголын үндэсний их сургууль" нэртэй болж, дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн хугацааны туршид дээр дурдсан сайдын тушаалуудад заасанчлан **сургалтын байгууллагын нэр, улсын бүртгэлд зохих өөрчлөлтийг хийлгэж бүртгүүлээгүй** боловч 1998-2002 онд "Чандмань-Эрдэнэ" коллеж, 2002-2004 онд Монголын үндэсний коллеж, 2004-2012 онд Монголын үндэсний дээд сургууль, 2012 оноос хойш Монголын үндэсний их сургууль нэрээр сургалтын байгууллагын үйл ажиллагааг, анх "Чандмань-Эрдэнэ" коллежид олгосон 980118 дугаартай тусгай зөвшөөрлийн дагуу явуулж иржээ",

Магадлалын хянавал хэсгийн 5.4-т "980118 регистрын дугаартай, "Монголын үндэсний дээд сургууль" нэртэй сургалтын байгууллага нь **2004 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн бол** "Монголын үндэсний их сургууль" ХХК /РД:5784344/ нь **2013 оны 12 дугаар сарын 26-ны өдөр "шинээр үүсгэн байгуулагдсан"** төлөвтэй бүртгэгдэж, хуулийн этгээдийн хэлбэрийг 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдөр "нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага" болгон өөрчилж, улмаар регистрын дугаарыг 9133615 болгон сольж бүртгүүлжээ",

Магадлалын хянавал хэсгийн 8.2-т "... энэ хэсгийн 5.2, 5.4-т дурдсанчлан "Чандмань-Эрдэнэ" коллежийн сургалтын байгууллагын ангиллыг Монголын үндэсний коллеж, Монголын үндэсний дээд сургууль, дараа нь Их сургууль болгож өөрчилсөн тохиолдол бүрд, зохих ангилалд нийцсэн нэр авч, тогтоосон хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлэхийг дээд боловсролын **сургалтын байгууллагын захиралд даалгасан сайдын тушаалыг биелүүлээгүйн** улмаас энэ тохиолдолд 2004 онд улсын бүртгэлд бүртгэгдсэн Монголын үндэсний дээд сургууль, эсхүл Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны А/454 дүгээр тушаалаар Их сургуулийн ангилалд шилжсэн "Монголын үндэсний дээд сургууль", эсхүл 2013 онд "хязгаарлагдмал хариуцлагатай компани" хэлбэрээр шинээр үүсгэн байгуулагдаж, 2015 онд "нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага" болж өөрчлөгдсөн "Монголын үндэсний их сургууль" нэртэй хуулийн этгээдүүдийн аль нь 980118 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэгч болох нь ойлгомжгүй нөхцөл байдал үүссэн ..." гэж тус тус дүгнэсэн.

Үүнээс үзэхэд дээд боловсролын сургалтын байгууллагын захирал дээд боловсролын байгууллагын ангилал өөрчлөгдөхөд зохих нэр авч, тогтоосон хугацаанд бүртгэлд бүртгүүлэх сайдын тушаалыг биелүүлэхийн оронд нэг хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг өөр нэг хуулийн этгээддээ ашиглуулж, нийтийн ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулж ирсэн болохыг шүүхээр тогтоогдсон бөгөөд үүний гол шалтгаан нь улсын бүртгэгчийг төөрөгдүүлж, хууран мэхлэх замаар Монголын үндэсний дээд сургуулийн тусгай зөвшөөрлийг Монголын үндэсний их сургууль ХХК-д шилжүүлэн бүртгүүлсэн үйл баримт болох нь тодорхой байна.

Ийнхүү шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон үйл баримтыг алсуураа өөрчлөх байдлаар шинэхэн түүх бүтээж нэхэмжлэгчид зориудаар давуу байдал бий болгож байгааг эх орны эрх зүйн зохицуулалт хэрхэвч дэмжихгүй юм.

Түүнчлэн нэгэнт хууль зөрчиж бүртгэл хийсэн болохыг бүртгэлийн байгууллага өөрөө тогтоож, дүгнэлт гаргасан байхад "... 980118 дугаартай тусгай зөвшөөрлийг сунгах, шинэ мэргэжил /хөтөлбөр/-ээр сургалт эрхлэх зөвшөөрөл нэмж олгох зэргээр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагийн зүгээс нэхэмжлэгчийг сургалтын үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжоор хангаж маргаангүй байсан ..." гэсэн өөр этгээдэд хамаарах үндэслэлээр хууль зөрчиж ирсэн нэхэмжлэгчийн санаатай үйлдлийг зөвтгөн тайлбарлаж, хууль зөрчигдөөгүй мэтээр дүгнэх үндэслэл болохгүй юм.

Нэхэмжлэгч шууд санаатай үйлдлээр хууль зөрчсөн болох нь хэрэгт цугларсан нотлох баримтаар эргэлзээгүй нотлогдохын зэрэгцээ өмнө гарсан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдож байхад тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулсан гэх үндэслэл нь хуульд зааснаар хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй байсан ч хамаардаг болж, илт хууль бус үйл ажиллагаа боловч зөвтгөгдөх замаар зүс хувирч байгаа нь байж болшгүй юм.

Иймд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 0564 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 0639 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү.

Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг хавсаргав.

ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

Б.ХАЛИУН

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Хяналтын журмаар гомдол гаргах тухай

“Монголын үндэсний их сургууль” НҮТББ-ын нэхэмжлэлтэй Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын ахлах байцаагч Ш.Уртнасанд холбогдох захиргааны хэргийг хянан шийдвэрлэсэн Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 564 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 0639 дугаар магадлалыг эс зөвшөөрч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д заасны дагуу хариуцагчаас дараах гомдлыг гаргаж байна.

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаагүй, хэрэгт цугларсан нотлох баримтыг хэргийн үйл баримттай уялдуулан дүгнэлт хийж чадаагүй, хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн тул шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах гэсэн үндэслэлээр тус гомлыг гаргаж байна.

Анхан шатны шүүх маргаан бүхий захиргааны актын үндэслэлийг судлаагүй бөгөөд шүүх хэргийг шийдвэрлэхдээ хэргээ бүрэн судалсан эсэхэд эргэлзээ төрүүлж байгаа давж заалдах шатны шүүхээс үүнийг зөвтгөхгүйгээр хэвээр үлдээж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй болсон.

Маргаан бүхий улсын байцаагчийн 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 6572 дугаар дүгнэлтэд “... Монголын үндэсний дээд сургуулийн регистрийн дугаар болох 980118 дугаараар улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон ... үүнээс хойш нэг жил дөрвөн сарын дараа байгуулагдсан Монголын үндэсний их сургууль ХХК-г улсын бүртгэлд бүртгэхдээ Монголын үндэсний их сургууль ХХК-д олгогдоогүй тусгай зөвшөөрлийг тус компанийн тусгай зөвшөөрлөөр бүртгэсэн ... энэ нь ... илт хууль бус байна” гэж шийдвэрлэсэн.

Товчоор хэлвэл, Монголын үндэсний их сургууль ХХК-д олгогдоогүй тусгай зөвшөөрлийг тус компанийн тусгай зөвшөөрлөөр бүртгэсэн улсын бүртгэл нь илт хууль бус байсан талаар дүгнэсэн.

Гэтэл үүнийг Монголын үндэсний их сургууль ХХК-д Монгол үндэсний дээд сургуулийн 980118 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгогдсон мэтээр тайлбарлаж, улмаар тусгай зөвшөөрөл олгосон нь илт хууль бус гэж улсын байцаагч шийдвэрлэсэн мэтээр дүгнэж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй байна.

Улсын байцаагчийн дүгнэлтээр Монголын үндэсний их сургууль ХХК-д 980118 дугаартай дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдоогүй байхад тус компанийн тусгай зөвшөөрөл гэж улсын бүртгэлд бүртгэсэн нь илт хууль бус байсан талаар тодорхой дүгнэсэн байгааг үгүйсгэж, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “тусгай зөвшөөрлийг олгосон

байгууллага нь хүчингүй болгох эрхтэй” гэсэн тухайн маргаанд хамааралгүй хуулийн зохицуулалтыг буруугаар тайлбарлан хэрэглэж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй юм.

Түүнчлэн анхан шатны шүүхээс цааш үүнийгээ дүгнэхдээ “... тусгай зөвшөөрлийг бүртгэсэн үйл ажиллагааг илт хууль бус гэж үзэх хариуцагчийн чиг үүрэг, эрх хэмжээнд нийцээгүй илт хууль бус захиргааны акт байна” гэжээ.

Анхан шатны шүүхээс тусгай зөвшөөрөл олгох харилцаа болон тусгай зөвшөөрлийг улсын бүртгэлд бүртгэх харилцааг өөр өөр харилцаа болохыг ялгаж салгахгүйгээр нэг харилцаа мэтээр дүгнэсэн нь хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Хариуцагчаас тусгай зөвшөөрлийг олгосон асуудлыг бус Монголын үндэсний их сургуульд ХХК-д олгогдоогүй тусгай зөвшөөрлийг тус компанийн тусгай зөвшөөрөл гэж улсын бүртгэлд бүртгэсэнийг илт хууль бус болохыг тогтоон шийдвэрлэсэн.

Гэтэл давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн энэ талаарх дүгнэлтийг зөвтгөхгүйгээр, энэ талаар гаргасан гомдлын үндэслэлд дүгнэлт өгөлгүйгээр шийдвэрлэсэн гэж үзэж байна.

Энэ хэсэгт анхан болон давж заалдах шатны шүүхээс утга агуулга болон логикийн алдаатай дүгнэлт хийсэн буюу улсын байцаагчийн дүгнэлтийг илт хууль бус захиргааны акт гэж дүгнэсэн атлаа ямар үндэслэлээр илт хууль бус гэж дүгнэж буй талаар дурдаагүйн зэрэгцээ харин улсын бүртгэгчийн бүртгэл илт хууль бус болохыг тогтоон шийдвэрлэсэн асуудлыг захиргааны актыг хүчингүй болгох зохицуулалттай хольж хутгаж тайлбарласан.

Тодруулбал, шүүхийн шийдвэрт Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.4, 37.5, 48 дугаар зүйлийн 48.2, 48.3 дахь хэсэгт заасныг үндэслэн захиргааны актыг хүчингүй болгох хөөн хэлэлцэх хугацааг зөрчсөн гэж үзсэн.

Захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоох болон захиргааны актыг хүчингүй болгох нь хоёр өөр үр дагавар бүхий захиргааны үйл ажиллагаа байдаг.

Гэтэл захиргааны хэргийн шүүх улсын байцаагчийн дүгнэлтийн захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоосон шийдвэрт хамаарах хэсэгт дүгнэлт хийхдээ Захиргааны ерөнхий хуулийн захиргааны актыг хүчингүй болгох зохицуулалтыг хэрэглэн дүгнэсэн нь үндэслэлгүй байна.

Анхан шатны шүүх хэргийн материалд авагдаагүй, нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс ч тайлбарласан асуудлаар буюу компани нэгдэх, нийлэх асуудлаар дүгнэлт хийсэн. Шүүх хуралдаанд нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс Монгол үндэсний дээд сургууль болон Монголын үндэсний их сургууль ХХК хоёр нь нэгдэж, нийлж, өөрчлөн байгуулагдаагүй талаар тайлбарласан.

Гэтэл анхан шатны шүүх “... аливаа хуулийн этгээд нь нэгдэх, нийлэх зэргээр өөрчлөн байгуулагдах ... бүрэн эрхтэй” гэж дүгнэсэн нь 5 хавтас хэргийн материалын хаана ч байхгүй дүгнэлтийг хийсэн гэж үзэхээр байна.

Монголын үндэсний коллеж нь 1998 онд байгуулагдсан Чандмань эрдэнэ нэртэй коллеж байсан, харин 2013 онд Монголын үндэсний их сургууль ХХК-г шинээр үүсгэн байгуулсан гэдэг нь улсын бүртгэлийн хувийн хэргийн баримтаар тодорхой нотлогдож байгаа. Өөрөөр хэлбэл Монголын үндэсний их сургууль ХХК нь аливаа хуулийн этгээдийн өөрчлөн байгуулагдсан хэлбэртэй хуулийн этгээд биш юм.

Түүнчлэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/421 дүгээр тушаалын 2-т улсын бүртгэлийн гэрчилгээг өөрчилж олгосныг залруулж, зохих хууль тогтоомжид нийцүүлж, улсын бүртгэл бүртгэх арга хэмжээ авахыг уламжилсан.

Тус тушаалын дээрх заалт нь хүчин төгөлдөр буюу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 0213 дугаар магадлалаар "... 2004 онэд улсын бүртгэлд бүртгэгдсэн Монголын үндэсний дээд сургууль ... 2015 онд "нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага" болж өөрчлөгдсөн "Монголын үндэсний их сургууль" нэртэй хуулийн этгээдүүдийн аль нь 980118 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч буюу дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэгч болох нь ойлгомжгүй нөхцөл байдал үүссэн ..." гэж дүгнэж тушаалын 2 дахь заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Энэхүү магадлал хуулийн хүчин төгөлдөр болсон болно.

Ийнхүү бодит байдалд Монголын үндэсний их сургууль нэртэй сургууль нь дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсэх нь тодорхойгүй аль хуулийн этгээд нь уг үйл ажиллагаа явуулах нь тодорхойгүй, ойлгомжгүй болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон байтал үүнийг харгалзан үзэхгүйгээр энэ асуудлыг шийдвэрлэхээр гарсан дүгнэлтийг хүчингүй болгож шийдвэрлэж байгаа нь үндэслэлгүй юм.

Түүнчлэн шүүхээс улсын байцаагчийн дүгнэлтийг зөвхөн регистрийн дугаарыг өөрчилсөн гэх үндэслэлээр гарсан мэтээр хэт явцуу дүгнэсэн нь учир дутагдалтай байна. Дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх нь тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа бөгөөд өөрт олгогдоогүй тусгай зөвшөөрлийг өөрийн мэтээр улсын бүртгэлд бүртгүүлсэн явдал нь хуульд нийцээгүй гэж үзэж, улсын бүртгэлийг зөвтгөн бүртгүүлэх, тусгай зөвшөөрлийг авсаны дараа улсын бүртгэлд бүртгүүлэхээр тус тус зааж шийдвэрлэсэн.

Үүнийг анхан болон давж заалдах шатны шүүхээс зөвхөн регистрийн дугаарын асуудал мэтээр дүгнэж шийдвэрлэсэн нь хэрэгт цугларсан баримт болон бодит байдалд нийцэхгүй бөгөөд хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болж чадаагүй байна.

"Монголын Үндэсний дээд сургууль" нь улсын бүртгэлийн бүртгэлд 980118 гэсэн регистрийн дугаартайгаар бүртгэгдсэн бол "Монголын Үндэсний Их Сургууль" ХХК нь 9133615 гэсэн регистрийн дугаартайгаар бүртгэгдсэн байх бөгөөд хоёр өөр бие даасан зорилго, үйл ажиллагаа бүхий хуулийн этгээдүүд юм.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас "Монголын Үндэсний Их Сургууль" ХХК-г улсын бүртгэлд бүртгэхдээ "Монголын Үндэсний дээд сургууль"-д олгогдсон 980118 дугаартай /регистрийн дугаараар олгогдсон/ сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийг "Монголын Үндэсний Их Сургууль" ХХК-ийнх мэтээр хандаж алдаатай бүртгэл хийсэн байсан.

Дээрх хоёр хуулийн этгээдийн регистрийн дугаарууд зөрүүтэй байхад үүнийг шалган тогтоолгүйгээр улсын бүртгэлд бүртгэсэн нь хуульд нийцэхгүй болно. Үүнийг шүүх шийдвэртээ бичсэн атлаа хуулийн этгээдийн улсын бүртгэл ямар хууль тогтоомжийг хэрхэн зөрчсөн болон уг бүртгэлийн улмаас хэний эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн, захиргаа өмнө гаргасан ямар зөрчлийг хэрхэн засч буй нь тодорхой тогтоогдохгүй байна гэж дүгнэсэн нь ойлгомжгүй байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 7/3699 дугаартай албан бичгээр “2013 онд иргэн Л.Мөнхбатын үүсгэн байгуулсан “Монголын Үндэсний их сургууль” ХХК-д боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал гараагүй байна” гэсэн, мөн хэрэг Боловсрол, шинжлэх ухааны яамны 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 2/2220 дугаар албан бичигт ч “Боловсрол, шинжлэх ухааны яам “Монголын үндэсний их сургууль” ХХК /РД:5784344/-д сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож байгаагүй болно” гэсэн. Ийнхүү “Монголын Үндэсний их сургууль” ХХК нь тусгай зөвшөөрөл авч байгаагүй байна.

Үүнийгээ анхан болон давж заалдах шатны шүүхээс маргаан бүхий харилцаанд хамааралгүй 2003 оны Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7, 18 дугаар зүйлийг хэрэглэн шийдвэрлэсэн нь үндэслэлгүй юм.

Хуулийн этгээдийн бүртгэл нь хууль тогтоомжид нийцэхгүй бөгөөд холбогдох хуулийг зөрчсөн болохыг тогтоож нэгэнт анх бүртгэсэн “Монголын Үндэсний Их Сургууль” ХХК-ийн улсын бүртгэлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн буюу анхны бүртгэл хүчингүй болсноор үүнийг үндэслэн бүртгэгдсэн Монголын Үндэсний Их Сургууль НҮТББ-ын улсын бүртгэл нь дагаж хүчингүй болохоор шийдвэрлэсэн.

Гэтэл үүнийг анхан шатны шүүхээс харгалзан үзэхгүйгээр тус бүртгэлийг хүчингүй болгоход тусдаа бие даасан үндэслэл байх ёстой мэтээр тайлбарлаж байгаа нь үндэслэлгүй бөгөөд нэг нь нэгийгээ улбаалан бий болсон бүртгэлийн харилцааг эхнээс нь зөвтгөх үүднээс ийнхүү шийдвэрлэсэн болохыг харгалзаж үзээгүй байна.

Түүнчлэн улсын байцаагчийн дүгнэлт нь Монголын Үндэсний Их Сургууль НҮТББ-ын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоогүй, ийм агуулга ч байхгүй тул тус сургуулийн үйл ажиллагааг явуулах боломжгүйд хүргэх мэтээр тайлбарласан үндэслэлгүй юм. Учир нь тусгай зөвшөөрлийн асуудлыг эрх бүхий этгээдээс шийдвэрлэснээр улсын бүртгэлийг хийлгэх боломжтой байгаа болно.

Иймд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 0564 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 0639 дугаар магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү.

ХАРИУЦАГЧ

 Ш.УРТНАСАН